213

“БАГАНУУРЫН ДУЛААНЫ СТАНЦ”ТӨХК-ИЙН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН ТУШААЛ

2012 оны 07 дугаар сарын 04-ны өдөр Дугаар 220 Багануур

Журам батлах тухай

“Баганууурын дулааны станц” ТӨХК-ийн захиргааны захирлын зөвлөлийн гишүүдийн 2012 оны 07 сарын 05-ны өдрийн хурлын шийдвэрийг үндэслэн **ТУШААХ НЬ:**

Нэг.Эрхэлсэн ажлаа мэргэжлийн өндөр түвшинд тогтмол сайн гүйцэж байгаа ажиллагсадад ур чадварын нэмэгдэл олгох журмыг хавсралтаар баталсугай.

Хоёр. Ур чадварын нэмэгдэл олгох журмыг 2012 оны 07 сараас эхлэн мөрдөж ажиллахыг Захиргаа хүний нөөцийн хэлтсийн дарга /Б.Нармандах/, Санхүү борлуулалтын хэлтсийн дарга /Ц.Энхцэцэг/-нарт зөвшөөрсүгэй.

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ Ш.БАЯНМӨНХ

Tushaal-2012

66

"Багануурын дулааны станц" ТӨХК-ийн гүйцэтгэх захирлын

2012 оны 07-р сарын 24-ний өдрийн 120 тоот тушаалын хавсралт

Ур чадварын нэмэгдэл олгох журам

Эрхэлсэн ажлаа мэргэжлийн өндөр түвшинд тогтмол сайн гүйцэтгэдэг буюу бусдаас илүү шинийг эрэлхийлэн сэтгэн бүтээмж бүрдүүлэн удирдан залж ур дүнтэй хөдөлмөрлөж байгаа ажиллагсдад ур чадварын нэмэгдэл олгоход энэхүү журмыг баримтална.

Нэг. Ур чадварын нэмэгдэл олгох шалгуур үзүүлэлтүүд.

Эрхэлсэн ажлаа бусдаас дэвшилтэт арга барилаар мэргэжлийн өндөр түвшинд үйлддэг, ажил ба ажилчдын тариф мэргэшлийн лавлахад өгөгдсөн мэргэжлийн дээд зэргийг эзэмшсэн ажилчин дараахь үзүүлэлтийг хангасан байна. Үүнд:

а. Мэргэжлээрээ 3-аас дээш жил тасралтгүй шаргуу ажилласан.

б.Өөрийн гэсэн ажлын онцлогтой.

в. Компаниа хөгжүүлэхийн төлөө чин эрмэлзэлтэй, манлайлах чадвартай, 2-оос доошгүй шинийг санаачилж, байгууллагадаа эдийн засгийн бодит хувь нэмэр оруулсан байх.

г. Болзошгүй технологийн зөрчил, ослыг гаргаагүй, урьдчилан сэргийлэх арга барилыг эзэмшсэн байх.

д. Ажлын шинэлэг арга барилыг залуучуудад өвлүүлэн дадлага туршлагатай болгосон байх.

е. Байгууллагын болон салбарын тэргүүний ажилтан болсон байх.

ё.ХХАА, ТАД-ийн эзэлжит болон аттестатчилсан шалгалтыг тогтмол амжилттай өгдөг байх.

Хоёр. Ур чадварын нэмэгдлийн хэмжээг тогтоох, олгох, хасах.

Ур чадварын нэмэгдлийг тухайн ажил, албан тушаал эрхэлж буй хугацаанд үндсэн цалингийн 30 хүртэл хувьтай тэнцэх хэмжээнд олгохдоо дараахь чиглэлийг баримтална.

2.1 Алба, хэлтэс, цех, хэсгийн инженер ур чадварын нэмэгдэл олгох шалгуур үзүүлэлтийг хангасан ажилтныхаа үнэлэмж, тасралтгүй ажилласан тухай тодорхойлолтын хамт ур нэмэгдлийг анхлан олгуулах болон цаашид үргэлжлүүлэн хувь хэмжээг нэмэгдүүлэх саналаа он оны эхний сарын 10-ны өдрийн дотор захиргаа хүний нөөцийн хэлтэст уламжилна.

2.2 Захиргаа хүний нөөцийн хэлтэс нь ур чадварын нэмэгдэл олгох ажилтнуудынхаа шалгуур үзүүлэлт, тасралтгүй ажилласан хугацааг харгалзан нэмэгдлийн хувь хэмжээг тогтоох асуудлыг боловсруулан захирлын зөвлөлийн хуралдаанд хэлэлцүүлж тус хурлын тэмдэглэлийг үндэслэн гүйцэтгэх захирлын тушаалаар баталгаажуулна.

2.3 Ур чадварын нэмэгдлийг тухайн албан тушаал хашиж байгаа хугацаанд жил бүр тогтоон олгох бөгөөд өөр ажилд шилжих буюу шалгуур үзүүлэлтээ хангалтгүй биелүүлвэл ур чадварын нэмэгдлийг олгохгүй.

2.4 Ур чадварын нэмэгдлийг ажилтнуудын цалин хөлсийг нэмэгдүүлэх амьдрал ахуйг харгалзах зэргээр хавтгайруулж олгохгүй.